

# “МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн  
тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон “Монос хүнс” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг тоолсон Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. “Монос хүнс” ХК-ийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг энэхүү тогтоолын хавсралт №01-ээр баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



~~Х.АНАНД~~

**Монос Хүнс ХК-ийн 2024 оны санхүү, үйл ажиллагааны тайланд өгөх  
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт**

Монос Хүнс ХК-ийн санхүү болон үйл ажиллагааны дүгнэлт, 2024 оны зорилтын биелэлтийн талаарх илтгэлийг Компанийн тухай хууль, Монос Хүнс ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцууллаа.

Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2024 онд компанийг удирдлагаар хангахдаа сайн засаглалын зарчмууд, Компанийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан дүрмийг мөрдлөг болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, үүрэг зөвлөмж, төлөвлөгөөг зорилтуудыг хэрэгжүүлэн, тайлант хугацаанд тогтмол хуралдаж компанийн үйл ажиллагаанд нийт 40 үүрэг зөвлөмж өгснөөс 96%-ийн биелэлттэй байна.

Засаглалын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Шүгэл үлээх журам, Мэдээллийн үйл ажиллагааны журам, Ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах журмыг хэлэлцэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа ISO 9001:2015 (Чанарын удирдлагын тогтолцоо), FSSC 22000:2018 (Хүнсний аюулгүй байдал), ISO 14001:2015 (Байгаль орчны удирдлага) зэрэг олон улсын стандартыг амжилттай нэвтрүүлж, Швейцарын SGS компанийн магадлан аудитаар дахин амжилттай баталгаажууллаа. Энэ нь компанийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн чанар олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөний илэрхийлэл юм.

2023-2024 оны голлох төсөл болох MFC 2.0-ийн төслийн хүрээнд эрүүл мэндийн шингэн хүнс болон хуурай хүнсний үйлдвэрлэл, чанарын хяналт баталгаажуулалт, инженер техникийн үйл ажиллагааг нэгдсэн байршилд төвлөрүүлж, шингэн хүнсний үйлдвэрийн хүчин чадлыг 2.5 дахин нэмэгдүүлж, автоматжуулсан технологи, ногоон шалгуурыг хангахуйц тоног төхөөрөмжийн сонголт бүхий 6300 мкв талбайтай эрүүл мэндийн нэгдсэн үйлдвэрээ ашиглалтад орууллаа. MFC 2.0 төсөл хэрэгжүүлэхдээ Экос брендийн савлагааг шинэчлэн 2024 оны 10-р сараас эхлэн хуванцрын хэмжээгээ 30% бууруулсан нь гурван сарын хугацаанд 43 тонн хуванцрын хэрэглээнээс зайлсхийж чадсан байна.

Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд сэргээгдэх эрчим хүчийг үйл ажиллагаандаа ашиглаж, гадна орчны талбайн гэрэлтүүлгийг нарны эрчим хүчээр хангаж, Баянгол цэцэрлэгт хүрээлэнд "MFC төгөл – 1000 мод" хөтөлбөрийн мод тарих ажлыг эхлүүлсэн. Үйл ажиллагаандаа усны зохистой хэрэглээг хэвшүүлэх, бууруулахыг зорьж, саарал усны 20%-ийг дахин ашиглажээ.

Нийт ажилтны 53% эрэгтэй, 47%-ийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж, хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй 11 ажилтан ажиллаж байна. 2024 онд ажлын байрыг 13.5%-иар нэмэгдүүлэв.

Бэлтгэн нийлүүлэгчийн 84%-ийг дотоодын бэлтгэн нийлүүлэгч эзэлдэг нь худалдан авалтын мөнгөн дүнгээр 52%-г бүрдүүлж байгаа юм.

Компанийн байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай үйл ажиллагааг үнэлж, Монголын Хүнсчдийн Холбооноос “Монгол Улсын Хүнсний Манлай Үйлдвэр” хэмээн өргөмжилсөн нь хамт олны хөдөлмөр, хичээл зүтгэлийн томоохон үнэлгээ боллоо.

Цэнэг брендийн 7 дахь нэр төрөл болох уушги цэвэрлэх бэлдмэлийг худалдаанд гаргасан нь цаг үеэ олсон, компанийн философид нийцсэн, хэрэглэгчдийн эрүүл мэндэд тустай эрэлттэй бүтээгдэхүүн болж чадсан. Энэ оны 9-р сард худалдаанд гарснаас хойш 450,000 ширхэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж борлуулалтын хэмжээ, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээний хувьд компанийн тэргүүлэх бүтээгдэхүүний нэг болжээ.

Монос Хүнс ХК-ийн хамт олон нь 2024 онд 38 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого, 4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж төлөвлөсөн зорилтоо 114%-аар биелүүлж, өмнөх оноос борлуулалтын орлогоо 20%-аар, цэвэр ашгаа 16%-иар өсгөж ажилласан. Үндсэн үйл ажиллагааг тогтвортой үр дүнтэй удирдахын зэрэгцээ компанийн ойрын ирээдүйд өсөлт авчрах MFC 2.0 төслийг амжилттай хэрэгжүүлсэн, мөн Киргиз улсын хүнсний зах зээлд бүтээгдэхүүнээ бүртгүүлж экспортын борлуулалтыг эхлүүлэн үр дүнтэй ажилласан зэргийг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс “МАШ САЙН” ажилласан хэмээн дүгнэж байна.

Компани нь цаашдын үйл ажиллагаандаа дараах чиглэлийг анхаарахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс зөвлөв. Үүнд:

- MFC 2.0 төсөл хэрэгжиж үйлдвэрийн хүчин чадал нэмэгдсэн учраас эрэлтээс хамаарсан тасалдлыг бууруулж, шингэн хүнсний борлуулалтыг нэмэгдүүлэх, төлөвлөсөн шинэ бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай таниулах
- MFC East log зүүн бүсийн агуулахын төслөө амжилттай хэрэгжүүлэх
- ТУЗ-өөр хэлэлцүүлж баталсан 2025 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах
- Үйл ажиллагаандаа хэвшүүлсэн сайн засаглалын зарчим, байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжлийн бодлогыг тууштай хэрэгжүүлэх, цаашид байгаль орчин нийгэм засаглалын тайланг олон нийтэд хүргэх, тайлагнах

**Монос Хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл**



**“МОНОС ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 04 дүгээр  
сарын 09-ний өдөр

Дугаар         

Улаанбаатар  
хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
2025 оны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Компанийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь заалтыг удирдлага болгон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос гаргасан саналыг 2025 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж, хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн цалин, урамшууллын хэмжээг болон хурлын үйл ажиллагаанд шаардагдах 2025 оны төсвийг энэхүү тогтоолын Хавсралт №01-д заасны дагуу баталсугай.
2. Энэхүү тогтоолоор батлагдсан төсөвт хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулал хорооны дарга/Х.Ананд/-д даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Х.АНАНД

2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн ТУЗ-ийн  
хурлын ...~~68~~... тоот тогтоолын Хавсралт №01



**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны зардлын төсөв**

	/мянган төгрөг/
<b>1. ТУЗ-ийн хурлын зардал</b>	<b>12,000</b>
• ТУЗ-ийн ээлжит хурал	8,000
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	4,000
<b>2. ТУЗ-ийн гишүүдийн цалин, НДШ</b>	<b>265,694</b>
• ТУЗ-ийн ээлжит хурал	241,694
• ТУЗ-ийн ээлжит бус хурал	24,000
<b>3. Сургалтын зардал</b>	<b>5,000</b>
<b>3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зардал</b>	<b>40,000</b>
<b>НИЙТ ДҮН</b>	<b>322,694</b>